

**Монгол Улсын Боловсрол, Соёл, Шинжлэх Ухааны Яам,
Монгол Улсын Эрүүл Мэндийн Яам
Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Их Сургууль**

МАНХДАЙН ОДСҮРЭН

**ХОДООДНЫ ҮРЭВСЭЛ, ШАРХЛАА ӨВЧНИЙ ҮЕД
ЧАЦАРГАНЫ
БЭЛДМЭЛИЙГ НЭМЭЛТ ХҮНСЭЭР ХЭРЭГЛЭХ**

Е- 720120 Дотор өвчин судлал

Эрдэм шинжилгээний ажлын удирдагч:

АУ-ны доктор Н. Бира

АУ-ны доктор, дэд профессор Г.Энхдолгор

Эрдэм шинжилгээний ажлын зөвлөх:

АУ-ны доктор, дэд профессор З.Ичинхорлоо

Эрдэм шинжилгээний ажлын шүүмжлэгч:

АУ-ны доктор, дэд профессор Г.Наран

Улаанбаатар 2006

ГАРЧИГ

УДИРТГАЛ	3
Судалгааны ажлын үндэслэл.....	3
Судалгааны ажлын зорилго, зорилт.....	5
Хамгаалахаар дэвшүүлж буй асуудал.....	5
Судалгааны ажлын шинэлэг тал.....	6
Судалгааны ажлын практик ач холбогдол.....	6
Судалгааны ажлын ажлын бүтэц хэмжээ.....	6
 НЭГ. ХЭВЛЭЛИЙН ТОЙМ.....	7
1.1. Чацаргана жимсний тухай.....	7
1.1.1. Чацаргана жимсний найрлага.....	8
1.1.2. Чацаргана жимсний анагаах ухааны үйлдэл, эмчилгээнд хэрэглэх.....	10
1.1.3. Чацарганыг эмчилгээ болон хүнс тэжээлд хэрэглэх төрлүүд	12
1.2. Ходоодны салст бүрхүүлийн гэмтлийн эмгэг жамын талаархи орчин үеийн ойлголт.....	17
1.3. Ходоодны үрэвсэл, шархлаа өвчин ба Хеликобактер пилори (НР) халдварын тухайд.....	20
1.4. Ходоодны үрэвсэл, шархлаа өвчний оношлогоо, эмчилгээний асуудалд.....	23
 ХОЁР. СУДАЛГААНЫ АРГАЧЛАЛ, ХЭРЭГЛЭГДЭХҮҮН.....	26
2.1. Судалгааны хүрээ.....	26
2.2. 24 цагийн рН метрийн шинжилгээ.....	27
2.3. Уян дурангийн шинжилгээ.....	30
2.4. Эмгэг бүтэц зүйн шинжилгээ.....	32
2.5. Чацарганы тосонцор бэлдмэл хэрэглэсэн аргачлал.....	32

ГУРАВ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ҮР ДҮН.....	34
3.1. ЧТБ ходоодны шүүрэлд нөлөөлөх байдлыг 24 цагийн рН метрийн шинжилгээгээр судалсан дүн	34
3.1.1. ЧТБ ходоодны хүчил саармагжуулах үйлдлийг судалсан дүн.....	35
3.1.2. ХАҮ, ХШӨ-ний үед ЧТБ-г хэрэглэн ходоодны хүчил шүүрлийн өөрчлөлтийг судалсан дүн.....	39
3.1.3. 24 цагийн рН метрийн шинжилгээний үед ходоодны биж шинжүүдийн өөрчлөлтийг судалсан дүн	41
3.2. ХАҮ, ХШӨ-ний үед ЧТБ хэрэглэж, салстад үзүүлэх нөлөөг уян дурангийн шинжилгээгээр судалсан дүн.....	43
3.3. ХАҮ, ХШӨ-ний үед ЧТБ хэрэглэн, салстад нөлөөлөх байдлыг эмгэг бүтэц зүйн шинжилгээгээр судалсан дүн.....	48
 ДӨРӨВ. СУДАЛГААНЫ АЖЛЫН ХЭЛЦЭМЖ.....	53
ДҮГНЭЛТ.....	66
ПРАКТИК ЗӨВЛӨМЖ.....	67
ТОВЧИЛСОН ҮГС.....	67
АШИГЛАСАН ХЭВЛЭЛ.....	68
ХАВСРАЛТ.....	
72-74	



УДИРТГАЛ

Судалгааны ажлын үндэслэл

Манай орны хүн амын хөдөлмөрийн чадвар алдалт, нас баралтын шалтгаан болж буй эмгэгүүдэд хоол боловсруулах эрхтэн тогтолцооны эмгэг орж байна.

Эрүүл Мэндийн Хөгжлийн Үндэсний төвийн 2004 оны судалгаагаар хоол боловсруулах эрхтэний эмгэгүүд нь нийт хүн амын өвчлөлийн II байранд, нас баралтын 4.82%, амбулатори, поликлиникийн нийт өвчлөлийн 16%, хэвтэн эмчлүүлэгсдийн 14% -ийг эзэлж, дотрын архаг эмгэгүүдээс дээгүүр байранд байгаа юм [16].

Монголын Гастроэнтерологич эмч нарын судалгаагаар хоол боловсруулах эрхтний эмгэгүүдээс тэргүүлэх байранд ходоодны үрэвсэлт өвчин 57%, ходоодны шархлаа өвчин 17%-ийг эзлэн, хөдөлмөрийн насны хүмүүсийн 48.4% буюу 30-49 насны хүмүүст зонхилон тохиолдож байгааг тогтоожээ [15].

Баруун Европын орнуудад 15-аас дээш насны хүмүүсийн 0.1-0.3%-д жил бүр ходоодны шархлаа бүртгэгдэж, ходоод, дээд гэдэсний шарх цоорох, шархнаас цус алдах хүндрэлийн улмаас 80% орчим нь мэс засал хийлгэдэг ба ихэвчлэн 65-аас дээш насанд илүү тохиолддог байна [22,27].

ОХУ-д хоол боловсруулах замын өвчлөлөөр 1000 хүн ам тутамд өсвөр насны хүүхдүүдийн 32.2%, насанд хүрэгсдийн 57.4% өвдөж байгааг тогтоож, үүнээс ходоодны үрэвсэлт өвчнөөр насанд хүрэгсэд 50%, ходоодны шархлаа өвчнөөр 8% орчим нь өвддөг гэж мэдээлжээ [18,23].

АНУ болон Европын насанд хүрсэн хүн амын 10% шархлаа

өвчнөөр өвддөг байна [24,31]. Манай оронд ходоодны шархлаа өвчин сүүлийн 10 жилд 2 дахин ихэссэн ба шархлааны улмаас хийгдсэн хагалгааны тоо сүүлийн 30 жилд 14.6 дахин өсчээ [15,16].

Ходоодны хорт хавдараар нас барах нь нийт хавдрын нас баралтын II байр буюу 14.8% байгаа нь ходоодны хавдрын өвчлөл өндөр, (100 мянган хүн амд 28.6) хожуу оношлогддог, эмчилгээний үр дүн сайнгүй, хавдарын урьдал өвчнүүдийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх аргууд хангалтгүй байгаатай холбоотой гэж үздэг [3,13,16].

Эдгээр тоо баримтаас үзэхэд ходоодны үрэвсэл, шархлаа өвчин өсөх хандлагатай өсвөр үе, залуучуудыг хамрах болсон төдийгүй хожмын хүндрэл ч буурахгүй байгаа нь анагаах ухааны төдийгүй нийгмийн тулгамдсан асуудал гэж дэлхий нийтээр үзэж байна [19].

Өвчлөлийн гол өсөлт нь хүн амын хүнсний буруу хооллолт, биологийн идэвхит амин дэм, илчлэг бага хоол хүнс хэрэглэх, хорт зуршил, эмийн замбараагүй хэрэглээ зэрэг нөлөөлөх хүчин зүйлүүдийн зэрэгцээ эрүүл ахуйн боловсрол хангалтгүй, оношлогоо эмчилгээг цаг алдалгүй чанартай бүрэн төгс хийлгэхгүй байгаатай холбоотой юм.

Орчин үед хоол боловсруулах дээд замын эмгэгүүд, ходоодны үрэвсэл, шархлаа өвчний эмчилгээнд хеликобактерийг устгах эмчилгээ (антибиотикууд, хүчлийг дарангуйлах, протоны шахуургыг хориглогч бүлгийн эмүүд, салстыг хамгаалах, салст бүрхүүлийг нөхөн төлжүүлэх эм бэлдмэлүүдийг) өргөнөөр хэрэглэн амжилт олж, дээрхи өвчнүүд 2-4 долоо хоногт сорвижин намжиж байгаа ч энэ нь хангалттай үзүүлэлт биш бөгөөд дээрхи өвчнүүдийн зөвхөн сэдрэлтийг устгах явдал гэж судлаачид үзэж байна [23,25,40].

Нийлэг эм, бэлдмэлүүд нь удаан хугацаагаар хэрэглэхэд эерэг үр дүнгийн зэрэгцээ гаж нөлөөтэй байдаг тул цэвэр байгалийн гаралтай, хор гаж нөлөө багатай бэлдмэлүүдийн судалгаа судлаачдын анхаарлыг олонтаа татах болсон бөгөөд ходоодны салст бүрхэвчийн тэсвэрт чанарыг дээшлүүлэх, салст бүрхүүлийн гэмтлээс урьдчилан сэргийлэх, эмчлэх үйлдэлтэй байгалийн гаралтай бүтээгдэхүүний үйлдлийн механизмыг

судлах асуудал судлаачдын өмнө тавигдаж байгаа гол зорилгуудын нэг болж байна [1, 2,10].

Өнөө үед хүн амын хооллолтын эрүүл ахуйн шаардлагад тавигдаж буй асуудал бол хүн амыг зохицуулах үйлчлэл бүхий бүтээгдэхүүнээр хангах явдал юм. Зохицуулах үйлчлэлтэй хүнсний бүтээгдэхүүн (Functional Diet) нь бие махбодын бодисын солилцоог дэмжин, эмчилгээний үйлдэл үзүүлдэг бодисыг агуулсан байдаг [12].

Эрт дээр үеэс чацаргана жимсийг Грек, Рим, Хятад, Орос, Түвд, Монголын уламжлалт эмчилгээнд уушги, элэг, ходоод гэдэс, зүрх, хавдар, арьс, эмэгтэйчүүд зэрэг олон төрлийн өвчнүүдэд салстыг нөхөн төлжүүлж шархыг анагаах, бодисийн солилцоог сайжруулах, биеийн дархлаа сайжруулах, хавдараас сэргийлэх зорилгоор хүнс тэжээл болон эмчилгээнд өргөн хэрэглэж ирсэн уламжлалтай [12,17, 28].

Манай оронд чацарганы үрийн болон жимсний тос, чацарганатай хивэг, дарс, ээзгий, чацарганы шүүс, тосон үрэл, тэжээлийн тос, хонины сүүлтэй уруулын будаг зэргийн судалгаанууд амжилттай хийгдэж эмчилгээ болон хүнсэнд өргөнөөр хэрэглэж байна [6].

Чацарганад бие махбодийн хэрэгцээт чухал амин дэмүүд, тос тосонцор бодис, эрдэс бодисууд хангалттай хэмжээтэй агуулагддаг нь эмчилгээнд хэрэглэгдэх боломжийг бүрдүүлж байгаа юм.

ЭМШУИС-ийн Биоанагаахын сургуулийн Анагаахын химийн тэнхимийн туршилт эрдэм шинжилгээний лабораторид З.Ичинхорлоо, Д.Энхмаа (2004) нарын судалсан чацарганы жимснээс гаргасан цэвэр байгалийн гаралтай чацарганы тосонцор бэлдмэлийг ходоодны архаг өвчнүүдийн үед нэмэлт хүнсний байдлаар хэрэглэн, үр дүнг тогтоон, анагаах ухааны практик ач холбогдолыг тодорхойлоход энэхүү судалгааны ажил чиглэгдлээ.

Судалгааны зорилго

Ходоодны үрэвсэл, ходоодны шархлаа өвчний үед чацарганы тосонцор бэлдмэлийг нэмэлт хүнсээр хэрэглэн, эмчилгээний үйлдлийг тогтоох.

Судалгааны зорилт

1. Чацарганы тосонцор бэлдмэлийн ходоодны хүчил саармагжуулах үйлдлийг тодорхойлох.
2. Чацарганы тосонцор бэлдмэлийн ходоодны архаг үрэвсэл, шархлааны үед ходоодны шүүрэлд нөлөөлөх байдлыг тогтоох.
3. Ходоодны архаг үрэвслийн үед чацарганы тосонцор бэлдмэл хэрэглэн ходоодны салстад үзүүлэх нөлөөг судлах.
4. Ходоодны шархлааны үед чацарганы тосонцор бэлдмэл хэрэглэн ходоодны салстад үзүүлэх нөлөөг тогтоох.

Хамгаалахаар дэвшүүлж буй асуудал

1. Ходоодны архаг үрэвсэл, ходоодны шархлаа өвчний үед чацарганы тосонцор бэлдмэлийг нэмэлт хүнсээр хэрэглэхэд ходоодны хүчлийг саар-магжуулан, хүчил шүлтийн тэнцвэржилтийг хангаж байгаа нь нэн чухал.
2. Ходоодны архаг үрэвсэл, ходоодны шархлаа өвчний үед чацарганы тосонцор бэлдмэлийг нэмэлт хүнсээр хэрэглэхэд, ходоодны салстын нөхөн төлжилтыг сайжруулах үйлдэлтэй.

Судалгааны ажлын шинэлэг тал

1. Манай орны эмнэлгийн практикт ходоодны архаг эмгэгүүдийн үед чацарганы тосонцор бэлдмэлийг нэмэлт хүнсээр хэрэглэх эмчилгээний үйлдлийг анх удаа судаллаа.
2. Чацарганы тосонцор бэлдмэл нь ходоодны шүүрэл ялгаруулах үйл ажиллагааны зохицуулгад эерэгээр нөлөөлж, хүчил-шүлтийн тэнцвэржилтийг хангаж байгааг илрүүлэв.
3. Чацарганы тосонцор бэлдмэл нь ходоодны салстын гэмтлийн үед ходоодны салстын нөхөн төлжилтийг дэмжин, эдгэрэлтийг түргэсгэх, үрэвслийн идэвхижилийг бууруулах нөлөө үзүүлж байгааг тогтоов.

Судалгааны практик ач холбогдол

1. Чацарганы тосонцор бэлдмэлийг ходоодны архаг үрэвсэл, шархлаа өвчний үед ходоодны салстын нөхөн төлжилтийг сайжруулах, үрэвслийг бууруулах зорилгоор эмчилгээний болон нэмэлт хүнсээр хэрэглэх анагаах ухааны үндэслэлийг гаргасан.
2. Чацарганы тосонцор бэлдмэл нь ходоодны хүчил ихэссэн үед ходоодны хүчиллэг шүүрлийг сул саармагжуулах, ходоодны хүчил багассан үед ходоодны хөндийн хүчиллэгийг ихэсгэх үйлдэлтэй байгаа нь өвчтөний ходоодны шүүрлийн онцлогоос хамаарч хэрэглэх боломжийг бүрдүүллээ.
3. Ходоодны архаг үрэвсэл, ходоодны шархлаа өвчний үед эмийн эмчилгээний дараа чацарганы тосонцор бэлдмэлийг хэрэглэснээр эмчилгээг дэмжих, өвчний эдгэрлийг түргэсгэх, сэдрэлээс урьдчилан сэргийлэх ач холбогдолтой гэж үзлээ.

Судалгааны ажлын бүтэц хэмжээ

Судалгааны ажлын диссертаци нь монгол хэлээр 74 хуудсанд 15 хүснэгт, 18 зураг багтааж бичсэн. Бүтээл нь дотроо удиртгал, хэвлэлийн тойм, судалгааны аргачлал, хэрэглэгдэхүүн, үр дүн, хэлцэмж, дүгнэлт, практик зөвлөмж, ашигласан хэвлэлийн жагсаалт, хавсралтаас бүрдэнэ.